



МОНГОЛ УЛСЫН
ХӨДӨЛМӨРИЙН САЙДЫН
ТУШААЛ

2015 оны 11 сарын 20 өдөр

Дугаар 4/2015

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.3 дахь хэсгийг үндэслэн ТУШААХ нь:

- “Мэргэжлээс шалтгаалах өвчнийг бүртгэх, мэдээлэх журам”-ыг нэгдүгээр хавсралтаар, “Мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас хөдөлмөрийн чадвараа алдсан ажилтныг бүртгэн, мэдээлэх маягт”-ыг хоёрдугаар хавсралтаар, “Мэргэжлээс шалтгаалсан өвчнийг нэгтгэн мэдээлэх тайлангийн маягт”-ыг туривдугаар хавсралтаар тус тус баталсугай.
- Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөдөлмөрийн яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга /Б.Баянмөнх/ Хөдөлмөрийн яамны харьяа Хөдөлмөрийн эрүүл мэнд судлалын төвийн дарга /Д.Мягмарсүх/, Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын Хөдөлмөр, нийгмийн хамгааллын хяналтын газрын дарга /Л.Төгсбаяр/ нарт үүрэг болгосугай.

САЙД

Г.БАЯРСАЙХАН



0000001666

Хөдөлмөрийн сайдын 2015
оньцгийн дугаар тушаалын
нэгдүгээр хавсралт

МЭРГЭЖЛЭЭС ШАЛТГААЛСАН ӨВЧНИЙГ БҮРТГЭХ, МЭДЭЭЛЭХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1. Энэ журмын зорилго нь мэргэжлээс шалтгаалсан өвчнийг бүртгэх, мэдээлэх, тайлагнах, дүн шинжилгээ хийх, мэдээллийн сан бүрдүүлэхэд оршино.
- 1.2. Мэргэжлээс шалтгаалсан өвчнийг бүртгэх, мэдээлэх үйл ажиллагаанд энэхүү журам болон Хөдөлмөрийн тухай, Нийгмийн даатгалын тухай, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай, Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан, дүрэм, журмыг мөрдөж ажиллана.
- 1.3. Энэ журмыг аймаг, дүүрэг, нийслэлийн Хөдөлмөрийн газар, хэлтэс, Эрүүл мэндийн газар, Мэргэжлээс шалтгаалсан өвчин, хөдөлмөрийн нөхцлийн асуудал хариуцсан байгууллага, Хөдөлмөрийн хяналтын байгууллага, улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж байгууллага хуульд өөрөөр заагаагүй бол нэгэн адил мөрдөнө.

Хоёр. Нэр томъёоны тодорхойлолт

- 2.1. Энэхүү журамд орсон нэр, томъёог дараах утгаар ойлгоно:
 - 2.1.1 “Мэргэжлээс шалтгаалсан өвчин” гэж хөдөлмөрлөх явцад үүссэн үйлдвэрлэлийн сөрөг хүчин зүйлийн нөлөөллөөс шалтгаалсан өвчнийг;
 - 2.1.2 “Мэргэжлээс шалтгаалсан өвчнийг оношлох” гэж Мэргэжлээс шалтгаалах өвчин, хөдөлмөрийн нөхцлийн асуудал хариуцсан байгууллага мэргэжлээс шалтгаалсан өвчнийг сэжиглэсэн тохиолдолд мэргэжлийн үзлэг, оношилгоо хийж өвчний оношийг тогтоохыг;
 - 2.1.3 “Эмнэлэг хөдөлмөрийн магадлагаа” гэж хүмүүсийн оюун ухаан, мэдрэхүй, бие бялдрын хэвийн үйл ажиллагаа нь алдагдаж хөдөлмөрийн чадвараа бүрэн буюу хэсэгчлэн алдсан шалтгаан, түүний хувь хэмжээ, хугацааг тогтоох мэргэжлийн үйл ажиллагааг;
 - 2.1.4 “Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комисс” гэж ердийн өвчин, ахуйн болон үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас даатгуулагчийн хөдөлмөрийн чадвар алдалт, түүний хувь хэмжээ, хугацааг тогтоох бүрэлдэхүүнийг;

2.1.5 “Мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас хөдөлмөрийн чадвараа алдсан ажилтан” гэж хөдөлмөрлөх явцад ажилтны бие махбодид үүссэн архаг удаан явцтай өвчин эрхтэн, бие махбодийн тогтоц, үйл ажиллагааг гэмтээж доройтуулсны улмаас үндсэн мэргэжлийн ажлыг хийж чадахгүй болсныг хэлнэ.

Гурав. Мэргэжлээс шалтгаалсан өвчнийг бүртгэх

3.1. Мэргэжлээс шалтгаалсан өвчин, хөдөлмөрийн нөхцлийн асуудал хариуцсан байгууллагын үүрэг.

3.1.1 Мэргэжлээс шалтгаалсан өвчин, хөдөлмөрийн нөхцлийн асуудал хариуцсан байгууллага/цаашид Хөдөлмөрийн эрүүл мэнд судлалын төв гэх/нь тус төвийн Эмнэлэг, хөдөлмөрийн магадлах комиссоос тогтоосон Эмнэлэг, хөдөлмөрийн магадлагааг үндэслэн мэргэжлээс шалтгаалсан өвчнийг оношлох, өвчний тохиолдол бүрийг бүртгэн мэдээллийн сан бүрдүүлнэ.

3.1.2 Мэргэжлээс шалтгаалсан өвчний тохиолдлыг “Мэргэжлээс шалтгаалсан өвчнийг бүртгэх маяг”-ын дагуу бүртгэнэ. “Мэргэжлээс шалтгаалсан өвчнийг бүртгэх маяг”-ыг Хөдөлмөрийн эрүүл мэнд судлалын төвийн дарга/захирлын тушаалаар батална.

3.1.3 Бүртгэлийг архивын нэгж болгон Хөдөлмөрийн эрүүл мэнд судлалын төвийн архивт 40 жил хадгална.

3.2. Ажил олгогчийн үүрэг

3.2.1. Ажил олгогч эсвэл Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцсан ажилтан нь мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас хөдөлмөрийн чадвараа алдсан ажилтны энэхүү журмын гуравдугаар хавсралтын дагуу бүртгэн авна.

3.2.2. Ажил олгогч мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас хөдөлмөрийн чадвараа алдсан ажилтныг эмчлэх, сувилах болон эрүүл мэндийн төрөлжсөн нарийн мэргэжлийн тусламж үйлчилгээ авахад дэмжлэг үзүүлнэ.

3.3. Эрүүл мэндийн байгууллагын үүрэг

3.3.1 Өрх, сумын эрүүл мэндийн төвүүд Эрүүл мэндийн сайдын “Эрүүл мэндийн статистик мэдээллийн талаар авах арга хэмжээний тухай” тушаалын дагуу мэргэжлээс шалтгаалсан өвчтэй иргэдийн, шилжилт хөдөлгөөн, нас барсан эсэх талаарх мэдээллийг бүртгэн авч Эрүүл мэндийн хөгжлийн төвийн мэдээллийн санд оруулна.

Дөрөв. Мэргэжлээс шалтгаалсан өвчнийг мэдээлэх

4.1. Аж ахуйн нэгж байгууллагын Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцсан ажилтан нь мэргэжлээс шалтгаалсан өвчтэй ажилтны

бүртгэлийг жил бүрийн 1 дүгээр сарын 10-ны дотор Хөдөлмөрийн эрүүл мэнд судлалын төвд хүргүүлнэ.

- 4.2. Хөдөлмөрийн эрүүл мэнд судлалын төв нь Эрүүл мэндийн хөгжлийн төвд нэгтгэгдсэн мэргэжлээс шалтгаалсан өвчтэй иргэдийн талаарх мэдээллийг авч, энэхүү тушаалын гуравдугаар хавсралтын дагуу нэгтгэн Хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Мэргэжлийн хяналтын байгууллага, Нийгмийн даатгалын ерөнхий газарт жил бүрийн 1 дүгээр сарын 20-ны дотор тус тус хүргүүлнэ.
- 4.3. Мэргэжлийн хяналтын байгууллага нь Хөдөлмөрийн эрүүл мэнд судлалын төвөөс ирүүлсэн мэдээг үндэслэн мэргэжлээс шалтгаалсан өвчин бүртгэгдсэн үйлдвэр, аж ахуйн нэгж байгууллагуудад эрсдэлд суурилсан хяналт тавих, хөдөлмөрийн нөхцлийг сайжруулах талаар чиглэл өгнө.
- 4.4. Мэргэжлийн хяналтын байгууллага нь мэргэжлээс шалтгаалсан өвчнийг мэдээлээгүй, мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас хөдөлмөрийн чадвараа алдсан ажилтанд актын дагуу үндсэн цалинг бууруулахгүйгээр хөдөлмөрийн нөхцөл солих, ажлын цаг хорогдуулах, хөдөлмөр зохицуулалт хийх, нөхөн төлбөр олгох зэрэг хууль, тогтоомжийг биелүүлээгүй үйлдвэр, аж ахуйн нэгж байгууллагуудад илэрсэн зөрчлийг арилгуулахаар албан шаардлага хүргүүлнэ.
- 4.5. Журмын 4.4- дэх хэсэгт заасан албан шаардлагыг хэрэгжүүлээгүй үйлдвэр, аж ахуйн нэгж байгууллагуудад холбогдох хууль тогтоомжид заасан бүрэн эрхийн хүрээнд захиргааны хариуцлага хүлээлгэнэ.
- 4.6. Мэргэжлээс шалтгаалах өвчний улсын хэмжээний мэдээг жил бүрийн дараа оны 2 дугаар сарын 10-ны дотор хэвлүүлэн гаргаж, нийтэд мэдээлнэ.

Тав. Санхүүжилт

- 5.1. Хөдөлмөрийн эрүүл мэнд судлалын төв нь Мэргэжлээс шалтгаалсан өвчний тухай улсын хэмжээний мэдээг үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангийн сургалт, сурталчилгааны зардлаас гаргуулж хэвлүүлнэ.

ооОоо

МЭРГЭЛЭЭС ШАЛТГАЛСАН ӨВЧНИЙ УЛМАС ХӨДӨЛМӨРИЙН ЧДВАР АЛДСАН АЖИЛТНЫГ БҮРТГЭХ, МЭДЭЭЛЭХ МЯГТ

Хөдөлмөрийн сайдын 2015 оны 4/3-р дугаар тушаалтын хөёрдугаар хавсралт

Тушаалтын хөйрдугаар хавсралт
Маят МШӨ-1

MAN

	A	Б	М	Насны бүлгээр	Ажилласан жилээр
1		Бүртгэгдсэн өвчлөл			
2		Эмэгтэй			
3		30 хүртэлх			
4		30-34			
5		35-39			
6		40-44			
7		45-49			
8		50-54			
9		55-59			
10		60-64			
11		65+			
12		10 хүртэлх			
13		10-15			
14		15-19			
15		20-24			
16		25-29			
17		30 +			
18		Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас, ан агуулур			
19		Уул уурхай, олборлолт			
20		Боловсруулах үйлдвэрлэл			
21		Цахилгаан, хий, уур агааржуулалт			
22		Ус хангамж, бохир ус зайлцуулах систем, хог хаягдлын менежмент, болон цэвэрлэх үйл ажиллагаа			
23		Барилга			
24		Бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклын засвар үйлчилгээ			
25		тээвэр ба агуулахын үйл ажиллагаа			
26		Зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээ,			
27		Мэдээлэл холбоо			
28		Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа			
29		Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа			
30		Мэргэжлийн шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа			
31		Удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа			
32		Төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн			
33		Боловсрол			
34		Хүний эрүүл мэнд ба нийгмийн халамжийн үйл ажиллагаа			
35		Урлаг үзвэр, тогтоом наадам			
36		Үйлчилгээний бусад үйл ажиллагаа			
37		Хүн хөлслүүлэн ажиллуулдаг өрхийн үйл ажиллагаа			
38		Олон улсын байгууллага, суурин төлөөлөгчийн үйл ажиллагаа			
39		МШӨ актны дагуу хөдөлмөрийн нөхцөл сольсон			
40		Ажлын байраар хангасан ажилтны тоо			
41		Дахин мэргэшүүлсэн ажилтны тоо			
42		Нэхэн олговор олгосон хүний тоо			
43		Ажлын байраар хангаагүй ажилтны тоо			

Тамга	Мэдээг нэгтгэсэн:	Статистикийн эмч	Овог, нар	Гарын үсэг
Хянасан:	Захирал	Овог, нар	Гарын үсэг	

он сар ёдер

МЭРГЭЖЛЭЭС ШАЛТГАЛСАН ӨВЧНИЙГ НЭТГЭН МЭДЭЭЛЭХ
ОНЫ УШИГЧИЙН ТАЙВАГЧИЙН МАГТ

20

Хүзүүний нүүцлэлийн хоорондийн зэрээрээчийн эмэг (M49)
Бусад хэсгийн нүүцлэлийн хоорондийн зэрээрээчийн эмэг (M50)
Өөр бүтгэлт антлагам бусад дөврөлтийн (M53)
Доржлам (түргүү ведж) (M54)
Мисэнг (M60)
Булганинини шохойжилт ба ясожилт (M61)
Булганинини бусад эмэг (M 62)
Өөр бүтгэлт антлагсан өвчиний үеийн булганингийн эмэг (M 63)
Синновит ба төсөөнийт (M65)
Үений бүрхүүл ба ширгэс аялдаа уллагах (M66)
Чөний гэр ба шөрөмөслийн бусад эмэг (M67)
Өөр бүтгэлт антлагсан өвчиний үеийн гэр ба шөрөмөслийн Аваалан хэгжлийн болт (M68)
Аваалан хэгжлийн болт дааралттай холбоотой зөвлөн бусад буторолтийн (M71)
Фондорбобласст эмэг (M72)
Өөр бүтгэлт антлагсан өвчиний үеийн зөвлөн эдийн
Мөрний эмэгччүйд (M75)
Тавхийнхас бусад додж мөрний энгээзлийн (M76)
Хавьгийн харшигийт Дөрвөлигт (L123)
Энгийн хавьгийн цоцолт Дөрвөлигт (L124)
Бусад гапны шаштгаагт нөхөн (L75)
Цахижиглан гүйцэл дамжуулаж шугаманд ортөх (M85)
Бусад толгойд цахижиглан гүйцэлийн үүрчилэд ортөх Тодорхойгийн цахижиглан гүйцэлийн үйнчилэд ортөх (M87)
Ионжих цайраг түршүүлж ортөх (M88)
Бүгд